

ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга			Гүйцэтгэл				
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (уялдаа, холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана) Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл 2015 оны 1 дүгээр сарын 16-нд байгуулагдсан			Төсөл, хөтөлбөрийн зорилго Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах				
2	Санхүүжилтийн эх үүсвэр Жайка олон улсын байгууллага			Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж Буцалтгүй тусламж + Улсын төсөв				
3	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/ Жайка олон улсын байгууллага / 5 жил /			Үндсэн хэрэгжүүлэх байгууллага Жайка төслийн нэгж, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Загвар аймаг болох Булган аймаг, Орхон аймгийн БОЭТ, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газрууд				
4	Төсөл хөтөлбөрийн зорилтууд			<p><i>Зорилт 1.</i> Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах чадавхи сайжрах</p> <p><i>Зорилт 2.</i> Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр сайжрах</p> <p><i>Зорилт 3.</i> Загвар аймагт эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо сайжрах</p>				
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Төсөв 285.316.937.00	Гүйцэтгэл 197.135.570,40		Хувь 80.35%		
		Үүнд:						
		Багц 1 Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх						
		Багц 2 Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ сургалт /AALS/						

		Багц 3 Хүүхдийн амилуулах суурь тусламж /PBL/						
6	<i>Төсөл хөтөлбөрийн зорилт:</i>			<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ</i>				
	1-р зорилтын хүрээнд: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалттай холбоотой явцын хяналт, үнэлгээний механизмыг сайжруулан бэхжүүлэх			<p>1. 2017 онд боловсруулагдсан явцын үнэлгээний хуудсаар 2018 оны 1,2-р саруудад Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. ЭМХТ-ийн Ерөнхий захиролын 27, 28 тоот албан бичгээр ХӨСҮТ-д илгээсэн. Үнэлгээний дүнд төвийн хариуцсан мэргэжилтнүүд зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Үнэлгээ, үнэлгээний тайланг ЭМЯ, Жайка олон улсын байгууллагын төслийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>2. ХӨСҮТ-д сүрьеэ судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хугацааг богиносгох, суралцагчдын тоог нэмэгдүүлэх хүсэлт гаргасны үндсэн дээр богиносгосон хөтөлбөр батлагдаж 2018 оны 10 сарын 1-нээс сүрьеэ судлал үндсэн мэргэшлийн сургалтад 19, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын төрөлжсөн мэргэшүүлэх сургалтад 13 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна.</p> <p>3. Төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулдаг 9 сургалт эрхлэгч байгууллагын сургалтын жилийн тайланд үнэлгээ хийж, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 2-ны хурлаар хэлэлцүүлж 9 байгууллагад сургалт эрхлэх эрх олгосон.</p> <p>4. Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын явцын үнэлгээний хуудсыг засварлахаар Япон улсын Олон улсын эрүүл мэндийн судалгааны төвийн Анагаах ухааны боловсролын төгсөлтийн дараах сургалтын ахлах зөвлөх Мураоко Акира, төслийн ахлах зөвлөх Инүэ Нобуаки нартай 2018 оны 11 сард хамтран ажилласан. Тус сайжруулсан үнэлгээний хуудсыг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Тус үнэлгээний хуудсаар ЭМХТ-ийн ерөнхий захирлаар батлуулсан удирдамжийн дагуу СЭМҮТ-д үнэлгээ хийсэн. Үнэлгээний тайланг ЭМЯ-ны ТЗУГ-т хүлээлгэн өгсөн.</p>				
	2-р зорилтын хүрээнд: Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах болон тасралтгүй сургалтын багц хэрэглэгдэхүүн боловсруулах			<p>1. Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтын удирдамж хөтөлбөрийг төвийн ерөнхий захирлаар 2018 оны 3-р сарын 12-ны А/31 тоот тушаалаар батлуулсан. Хуваарийн дагуу 1,3,4,5,9,1,11 саруудад нийт 10 удаагийн сургалтууд явагдаж сургалт эрхлэгч байгууллага, Аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж 279 эмнэлзүйн сургагч багш нар бэлтгэгдсэн. Эдгээр бэлтгэгдсэн эмнэлзүйн сургагч багш нараас чиглүүлэгч багш бэлтгэхээр 2018 оны 5 сарын 17-19-ний өдрүүдэд 11 сургалт эрхлэгч байгууллагын 23 багшийг чиглүүлэгч багш болгосон.</p> <p>2. Яаралтай тусламжийн чиглэлээр амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтний биеийн байдалд үнэлгээ өгөх амилуулах лавшруулсан тусламжийн</p>				

		<p>арга техникийг эзэмшүүлэх сургалтыг 10 удаа зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг Япон улсын AALS сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулж, нарийн ажилбар гүйцэтгэх боломжтой маникен ашиглан зохион байгуулсан. Сургалтад 21 аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 18 байгууллага, сургалт эрхлэх 16 байгууллагын 80 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>3. Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэгч сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, тус хөтөлбөрийн дагуу 2018 оны 6-9 сарын хооронд 4 удаа зохитн байгуулж, нийт 48 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</p>				
	<p>3-р зорилтын хүрээнд: Загвар аймагт яаралтай тусламж, хүүхэд зэрэг сонгосон чиглэлээр багц цагийн сургалт зохион байгуулах, дээд шатлалын эрүүл мэндийн байгууллага нь дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагыг удирдан чиглүүлж ажиллах шаталсан тогтолцоог бий болгох</p>	<p>1. Орхон аймагт 2018 оны 9-р сарын 12-14-ний өдрүүдэд Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 24 эмч хамрагдсан.</p> <p>2. Орон нутагт төгсөлтийн дараах сургалт явуулахаар Орхон аймгийн БОЭТ, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд Ерөнхий мэргэшил судлал, үндсэн мэргэшлийн сургалт шинээр явуулах эрх олгох үйл ажиллагаанд журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, Эрүүл мэндийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, эрх олгогдсон. 2018-2019 оны хичээлийн жилийн Ерөнхий мэргэшил судлал, үндсэн мэргэшлийн сургалтад Орхон аймгийн БОЭТ-д 4, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд 16 суралцагч элсэн суралцаж байна.</p>				
7	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p> <p>Төсөл амжилттай хэрэгжиж байна.</p>	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал, дутагдалтай талуудыг бичнэ				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ				
9	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлтийн дундаж 80.5%	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
			3	78%	88%	75%
10	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/					